


2024 ОНЫ 04 ДУГААР САРЫН УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

Хаврын улиралд цаг агаар тогтворгүй байдагтай холбоотой агаарын температурын хэлбэлзэл ихэсдэг. Манай орны 4 дүгээр сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг болон томоохон гол, нуурын сав газраар 0°C (32°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар +6°C (42.8°F) –аас +12°C (53.6°F), бусад нутгаар 0°C –аас +5°C (32°F – аас 41°F) хүйтэн байдаг байна.


Монгол орны хэмжээнд 4 дүгээр сард хур тунадас бага унадаг ба ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 3 хувьтай тэнцдэг. Тус сард Булган, Хөвсгөлийн зүүн хойд хэсгээр 10-17 мм, Ховд, Говь-Алтай болон нутгийн өмнөд хэсгээр 0.2-4.9 мм бусад нутгаар 5.0-10 мм тунадас ордог байна .



Зураг 1. 1991-2020 оны 4 дүгээр сарын агаарын дундаж температур, нийлбэр нийлбэр хур тунадасны орон зайн тархалт


2024 оны 4 дүгээр сарын агаарын дундаж температур өмнөх жилээс 4.1°C-аар, ОЖД-аас 1.6°C-аар тус тус дулаан байсан ба 1940 оноос хойш тохиолдож байгаа 8 дахь дулаан сар болж өнгөрлөө. Сарын дундаж агаарын температурын ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нийт нутгийн 71.3% нь дунджаас 1.0–ээс 3.4°C-аар дулаан, 27.1% нь дунджийн орчим, 1.6% нь дунджаас хүйтэн байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 11.6 мм хур тунадас орсон нь өмнөх жилээс 112.9%-иар, ОЖД-аас 74.18%-иар ахиу бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 6 дахь ахиу тунадастай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 65.1% нь дунджаас ахиу, 31.8% нь бага, 3.1% -д дунджийн орчим хур тунадас унасан байна.




Зураг 2. 2024 оны 4 дүгээр сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын газарзүйн тархалт

Монгол орноор болон 4 бүсээр хуваан дунджилсан 4 дүгээр сарын хоногийн дундаж агаарын температурын явцыг авч үзэхэд (Зураг 3) 1 болон 2 дугаар 10 хоногийн ихэнх хугацаанд нийт нутгаар ОЖД-аас 1.1-ээс 11.2°C-аар дулаан, 1 дүгээр 10 хоногийн эхэнд зүүн бүс нутгаар, 2 дугаар 10 хоногийг дунд үед баруун болон төвийн нутгаар бага зэргийн хүйтрэлт ажиглагдсан байна. Харин 3 дугаар 10 хоногийн эхээр нийт нутгаар ОЖД-аас 0.6-ээс 5.3°C-аар дулаан, бусад хугацаанд ОЖД-аас -0.5-аас -7.0°C-аар хүйтэн байжээ. Хур тунадасны хувьд 1 болон 2 дугаар 10 хоногт ихэнх нутгаар, 3 дугаар 10 хоногт нийт нутгаар харьцангуй ахиу хур тунадас орсон байна.



Зураг3. Хоногийн дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Энэ сард агаарын температурын үнэмлэхүй их утга Дорноговийн Эрдэнэ суманд 27.5°C, үнэмлэхүй бага утга Баянхонгорын Баянбулагт -22.4°C хүрчээ. Хөрсний температурын үнэмлэхүй их утга Баянхонгорын Эхийнголд 54°C, үнэмлэхүй бага утга Баянхонгорын Баянбулагт -27°C хүрч хүйтэрсэн. Хоногт хамгийн ихдээ Өмнөговийн Булган суманд 26-ны өдөр 19.9 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 954.2гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 755.6гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Ховдын Зэрэгт 38 м/с хүрчээ.



Зураг 4. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд